ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ХЭА-2026/164/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:
Audit.mn
Хэнтий аймаг
Чингис хот
2026 он


Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 мэйл хаяг: Khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 мэйл хаяг: Oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Энх-Амгалан
Утас: 91119424 мэйл хаяг: Enkh-Amgalang@audit.gov.mn

Ари файнэнс аудит ХХК-ийн Захирал: Д.Ариунаа
Утас: 99088151 мэйл хаяг: arifin.audit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.24 № 275

танай ____________ -ны № ______________ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯН-АДАРГА СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.АНХБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1,8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүү байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр бус “бараа үйлчилгээний бусад зардал” ангиллаар нэгтгэн төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

**Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 20,551.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 17,029.0 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэлд тооцоо бодсон акт үйлдээгүй, байгууллагын гэрчилгээний хөрөнгийн дүнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй зөрчлүүдэд 2 албан шаардлага, 3,522.1 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмжийг хүргүүллээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудал**

Баян-Адрага сумын Ерөнхий боловсролын сургууль нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний 24 зорилтын хүрээнд 43 арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэл 88.2 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

***2.1* Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **493,165,766.33** | **585,053,507.91** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **365,035,387.64** | **469,064,796.51** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **365,035,387.64** | **469,064,796.51** |
| **31210** | **Төгрөг** | **365,035,387.64** | **469,064,796.51** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 365,035,387.64 | 469,064,796.51 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **128,130,378.69** | **115,988,711.40** |
| **35400** | **Хангамжийн материал** | **128,130,378.69** | **115,988,711.40** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,099,000.00 | 2,492,800.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 40,200,867.60 | 31,521,755.60 |
| 35450 | Барилгын засварын материал | 9,300,000.00 | 10,500,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 4,225,750.00 | 4,413,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 48,642,761.09 | 44,258,155.80 |
| 35600 | Мал амьтад | 22,662,000.00 | 22,803,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,997,229,252.68** | **3,772,950,827.03** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **3,997,229,252.68** | **3,772,950,827.03** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **3,950,411,252.68** | **3,703,378,827.03** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,948,865,239.00 | 3,948,512,339.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (393,352,869.82) | (524,923,069.28) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 16,000,000.00 | 16,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (11,333,333.22) | (14,666,666.52) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 394,241,922.22 | 403,790,922.31 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (111,006,908.12) | (223,297,357.23) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 137,926,355.92 | 145,406,355.92 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (59,772,310.63) | (75,804,611.94) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,108,970.00 | 2,108,970.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (15,000.00) | (497,242.56) |
| 39217 | Ном | 26,749,187.33 | 26,749,187.33 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **46,818,000.00** | **69,572,000.00** |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 46,818,000.00 | 69,572,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2** | **4,490,395,019.01** | **4,358,004,334.94** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **58,401,603.00** | **37,402,353.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **58,401,603.00** | **37,402,353.00** |
| **41300** | **Өглөг** | **58,401,603.00** | **37,402,353.00** |
| **41360** | **Бусад өглөг** | **58,401,603.00** | **37,402,353.00** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,431,993,416.10** | **4,320,601,981.94** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **4,431,993,416.10** | **4,320,601,981.94** |
| **51100** | **Засгийн газрын оруулсан капитал** | **394,998,578.29** | **394,998,578.29** |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 394,998,578.29 | 394,998,578.29 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **4,036,555,524.60** | **3,925,164,090.44** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,851,805,120.46 | 4,036,555,524.60 |

| | | | |
|---|---|---|---|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 184,750,404.14 | (111,391,434.16) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 439,313.21 | 439,313.21 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5** | **4,490,395,019.10** | **4,358,004,334.94** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **2,027,894,373.00** | **2,214,727,452.30** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **85,387,173.00** | **2,214,727,452.30** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **85,387,173.00** | **60,447,052.30** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **14,219,650.00** | **13,723,000.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,248,800.00 | 140,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 12,970,850.00 | 13,583,000.00 |
| 120009 | Бусад орлого | | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 54,821,287.80 | 22,754,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 16,346,235.20 | 23,970,052.30 |
| **122** | **Тусламжийн орлого** | **-** | **2,154,280,400.00** |
| **1221** | **Хандив тусламж /дотоод/** | **-** | **2,154,280,400.00** |
| **12211** | **Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого** | **-** | **2,154,280,400.00** |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | | 1,846,848,800.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | | 307,431,600.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,942,507,200.00** | **-** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,657,022,400.00** | **-** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,657,022,400.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх** | **285,484,800.00** | **-** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн/ | 285,484,800.00 | 0 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,827,352,015.72** | **2,316,311,886.46** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,827,352,015.72** | **2,316,311,886.46** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,768,226,340.72** | **2,225,711,403.36** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,042,655,967.86** | **1,296,781,583.91** |
| 210101 | Үндсэн цалин | 689,246,059.69 | 792,643,939.78 |
| 210102 | Нэмэгдэл | 325,772,846.17 | 411,127,339.91 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 40,043,604.00 |
| 210104 | Урамшуулал | 27,637,062.00 | 52,966,700.22 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **132,571,607.93** | **161,854,183.88** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 91,406,898.87 | 111,005,285.25 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 10,955,715.21 | 13,315,756.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 5,367,610.95 | 6,720,283.21 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 4,968,275.07 | 6,185,117.60 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 19,873,107.83 | 24,627,741.82 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **281,278,763.73** | **296,044,246.90** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 18,574,633.73 | 27,778,946.90 |
| 210302 | Түлш, халаалт | 253,772,130.00 | 254,284,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,932,000.00 | 13,980,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **68,378,960.00** | **92,300,430.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 68,378,960.00 | 92,300,430.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,000,000.00** | **10,000,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 6,000,000.00 | 10,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **20,057,937.39** | **21,938,546.34** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,248,800.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 18,809,137.39 | 21,938,546.34 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **217,283,103.81** | **346,792,412.33** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 58,961,436.00 | 72,468,806.59 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,605,060.00 | 10,262,180.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 151,716,607.81 | 264,061,425.74 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **59,125,675.00** | **89,213,130.00** |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **59,125,675.00** | **89,213,130.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 59,125,675.00 | 89,213,130.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | - |
| **21311** | **Засгийн газрын дотоод шилжүүлэг** | **1,206,036.27** | **1,387,353.10** |
| **213112** | **Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал** | **1,206,036.27** | **1,387,353.10** |
| 2131121 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | 1,206,036.27 | 1,387,353.10 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **200,542,357.28** | **(101,584,434.16)** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **(14,585,916.87)** | **(9,807,000.00)** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | (2,321,916.87) | |
| | Үнэ төлөргүй бараа материалт гарсан зардал | (12,264,000.00) | (9,807,000.00) |
| **VII** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)** | **-** | **(9,807,000.00)** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)** | **200,542,357.28** | **(111,391,434.16)** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **1,956,727,050.00** | **2,168,003,400.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **14,219,850.00** | **13,723,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **14,219,850.00** | **13,723,000.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **14,219,850.00** | **13,723,000.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,249,000.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 12,970,850.00 | 13,723,000.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого /орон нутаг/ | 285,484,800.00 | 307,431,600.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,657,022,400.00** | **1,846,848,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,657,022,400.00** | **1,846,848,800.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,657,022,400.00 | 1,846,848,800.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,717,395,171.35** | **2,063,973,991.13** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,717,395,171.35** | **2,063,973,991.13** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,655,897,460.08** | **1,975,317,508.03** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,042,655,968.03** | **1,296,781,583.91** |
| 210101 | Үндсэн цалин | 689,246,059.86 | 792,108,702.52 |
| 210102 | Нэмэгдэл | 325,772,846.17 | 411,662,577.17 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 40,043,604.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 27,637,062.00 | 52,966,700.22 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **132,571,607.93** | **161,854,183.88** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 91,406,898.87 | 111,005,285.25 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 10,955,715.21 | 13,315,756.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 5,367,610.95 | 6,720,283.21 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 4,968,275.07 | 6,185,117.60 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 19,873,107.83 | 24,627,741.82 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **281,278,763.73** | **296,044,246.90** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 18,574,633.73 | 27,778,946.90 |
| 210302 | Түлш, халаалт | 253,772,130.00 | 254,284,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,932,000.00 | 13,980,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **69,430,680.00** | **94,431,680.00** |
| 210502 | Хоол, хүнс | 69,430,680.00 | 94,431,680.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,000,000.00** | **10,000,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 6,000,000.00 | 10,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **26,549,137.39** | **22,858,696.34** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 26,549,137.39 | 22,858,696.34 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **97,411,303.00** | **93,347,117.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 84,966,143.00 | 83,084,937.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,445,160.00 | 10,262,180.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **61,497,711.27** | **88,656,483.10** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **60,291,675.00** | **87,269,130.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 60,291,675.00 | 87,269,130.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **1,206,036.27** | **1,387,353.10** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,206,036.27 | 1,387,353.10 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **239,331,878.65** | **104,029,408.87** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **239,331,878.65** | **104,029,408.87** |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **365,035,387.64** |
| **20** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **469,064,796.51** |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 394,998,578.29 | 12,974,693.57 | 3,839,269,740.10 | **4,247,243,011.96** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 12,535,380.36 | **12,535,380.36** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **394,998,578.29** | **12,974,693.57** | **3,851,805,120.46** | **4,259,778,392.32** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | | (12,535,380.36) | | **(12,535,380.36)** |
| 9 | Тайлант үеийн үр дүн | | | 184,750,404.14 | **184,750,404.14** |
| **10** | **2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **394,998,578.29** | **439,313.21** | **4,036,555,524.60** | **4,431,993,416.10** |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **394,998,578.29** | **439,313.21** | **4,036,555,524.60** | **4,431,993,416.10** |
| 19 | Тайлант үеийн үр дүн | | | (111,391,434.16) | (111,391,434.16) |
| **20** | **2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **394,998,578.29** | **439,313.21** | **3,925,164,090.44** | **4,320,601,981.94** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **2,212,474,200.00** | **2,166,616,046.90** | **43,858,153.10** | **98.0** |
| **12** | **Татварын бус орлого** | **2,212,474,200.00** | **2,166,616,046.90** | **43,858,153.10** | **98.0** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 15,723,000.00 | 13,723,000.00 | 2,000,000.00 | 87.3 |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 15,723,000.00 | 13,723,000.00 | 2,000,000.00 | 87.3 |
| **122** | **Тусламжийн орлого** | **2,196,751,200.00** | **2,152,893,046.90** | **43,858,153.10** | **98.0** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 1,889,319,600.00 | 1,846,848,800.00 | 42,470,800.00 | 97.8 |
| 122005 | Төсвөөс санхүүжих /орон нутаг/ | 307,431,600.00 | 306,044,246.90 | 1,387,353.10 | 99.5 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,573,952,800.00** | **2,062,586,638.03** | **511,366,161.97** | **80.1** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,573,952,800.00** | **2,062,586,638.03** | **511,366,161.97** | **80.1** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,482,659,900.00** | **1,975,317,508.03** | **507,342,391.97** | **79.6** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,727,517,200.00** | **1,296,781,583.91** | **430,735,616.09** | **75.1** |
| 210101 | Үндсэн цалин | 1,052,525,100.00 | 792,108,702.52 | 260,416,397.48 | 75.3 |
| 210102 | Нэмэгдэл | 637,254,500.00 | 411,662,577.17 | 225,591,922.83 | 64.6 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 40,043,604.00 | (40,043,604.00) | |
| 210104 | Урамшуулал | 37,737,600.00 | 52,966,700.22 | (15,229,100.22) | 140.4 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **215,939,600.00** | **161,854,183.88** | **54,085,416.12** | **75.0** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 146,838,900.00 | 111,005,285.25 | 35,833,614.75 | 75.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,275,100.00 | 13,315,756.00 | 3,959,344.00 | 77.1 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,637,600.00 | 6,720,283.21 | 1,917,316.79 | 77.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,637,600.00 | 6,185,117.60 | 2,452,482.40 | 71.6 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 34,550,400.00 | 24,627,741.82 | 9,922,658.18 | 71.3 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **297,431,600.00** | **296,044,246.90** | **1,387,353.10** | **99.5** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 27,846,800.00 | 27,778,946.90 | 67,853.10 | 99.8 |
| 210302 | Түлш, халаалт | 254,284,800.00 | 254,284,800.00 | - | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 15,300,000.00 | 13,980,500.00 | 1,319,500.00 | 91.4 |
| **2105** | **Нормативт зардал** | **105,279,300.00** | **94,431,680.00** | **10,847,620.00** | **89.7** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | | - | |
| 210502 | Хоол, хүнс | 105,279,300.00 | 94,431,680.00 | 10,847,620.00 | 89.7 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | | - | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **10,000,000.00** | **10,000,000.00** | **-** | **100.0** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | | - | |
| 210604 | Урсгал засвар | 10,000,000.00 | 10,000,000.00 | - | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **30,644,700.00** | **22,858,696.34** | **7,786,003.66** | **74.6** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 30,644,700.00 | 22,858,696.34 | 7,786,003.66 | 74.6 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **95,847,500.00** | **93,347,117.00** | **2,500,383.00** | **97.4** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 85,582,200.00 | 83,084,937.00 | 2,497,263.00 | 97.1 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,265,300.00 | 10,262,180.00 | 3,120.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **91,292,900.00** | **87,269,130.00** | **4,023,770.00** | 95.6 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **91,292,900.00** | **87,269,130.00** | **4,023,770.00** | **95.6** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 91,292,900.00 | 87,269,130.00 | | |
| **8** | **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ** | **(361,478,600.00)** | **104,029,408.87** | | |
| **9** | **АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **361,478,600.00** | **(104,029,408.87)** | | |
| **7** | **Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт** | **361,478,600.00** | **(104,029,408.87)** | | |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **365,035,387.64** | | |
| **20** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **469,064,796.51** | | |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 20,551.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 17,029.0 мянган төгрөгийн 1 алдааг[1] аудитын явцад залруулж, хөрөнгийн тооллого, байгууллагын эрхий бүртгэлийн гэрчилгээтэй холбоотой зөрчилд[2] 2 албан шаардлага, 3,522.1 төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн.

### 3.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Тайлант онд худалдаж авсан 17,029.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд бараа үйлчилгээний зардлаар бүртгэсэн.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитаар нийт 3,522.1 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс 2 зөрчилд албан шаардлага, 3,522.1 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

**3.2 Албан шаардлага**

1. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх"; 13 дугаар зүйлийн 13.1. “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”; Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалтыг зөрчиж, “үнэн зөв байх”, ”иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн Биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх**

2. Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй малын тооллого хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1. "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" заалт; 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." заалтууд, санхүүгийн тайлангийн "үнэлгээ", "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн Биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх**

**3.3 Зөвлөмж**

**1.Бараа материалтай холбоотой асуудал**

**Илрүүлэлт-1** Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэж ажиллаагүй батлагдсан төсвийг 3,522.1 мянган төгрөгийг хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4."бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх" заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх”, "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж**: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулж байх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас

хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | То о | Дүн |
| Зардлыг буруу тусган илэрхийлсэн | 1 | 17,029.0 | | | 1 | 17,029.0 | 1 | 17,029.0 | | | | |
| **Дүн** | **1** | **17,029.0** | | | **1** | **17,029.0** | **1** | **17,029.0** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Т оо | Дүн | Т о о | Дүн | Т о о | Албан тушаалтны тоо | То о | Дүн |
| Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй байна. | 1 | | | | 1 | | | | | | | |
| Хөрөнгийн тооллогыг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй. | 1 | | | | 1 | | | | | | | |
| **Дүн** | **2** | | | | **2** | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Т оо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэж ажиллаагүй батлагдсан төсвийг хэтрүүлсэн байна. | 1 | 3,522.1 | | | | | 1 | 3,522.1 |
| **Дүн** | **1** | 3,522.1 | | | | | **1** | 3,522.1 |
| **Нийт дүн** | **1** | **3,522.1** | | | | | **1** | **3,522.1** |